




GOBI

ГОВЬ ХК-ИЙН
2025 ОНЫ 1-Р УЛИРЛЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

ТАЙЛАНТ ХУГАЦАА: 2025.01.01 - 03.31



1.	КОМПАНИЙН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА	3
2.	САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	9
3.	2025 ОНЫ I УЛИРАЛД БИД	18
4.	ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ	24
5.	КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ	34



КОМПАНИЙН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА





GOBI

ГОВЬ ХК нь 100 хувь Монгол ноолуураар бүтээгдэхүүн үйлдвэрлэгч үндэсний ууган компани бөгөөд олон зууныг дамжин уламжлагдан ирсэн ур ухааныг орчин үеийн үйлдвэрлэлийн дэвшилтэт технологитой хослуулан тав тухтай, удаан эдэлгээтэй загварууд үйлдвэрлэн хэрэглэгчдэдээ хүргэдэг билээ.

Бид нүүдэлчин соёлтой малчин ардтайгаа хамтран ажиллаж, Улаанбаатар хот дахь үйлдвэртээ бүх бүтээгдэхүүнээ хариуцлагатай үйлдвэрлэдэг.

70 гаруй хувь нь эмэгтэйчүүдээс бүрдсэн 1,700 орчим ажилтантай ГОВЬ компани нь эх орондоо ажлын байр бий болгож, дэлхий дахинд хамгийн зөөлөн, тансаг ноолууран бүтээгдэхүүнийг бахархалтайгаар хүргэж өдгөө 44 дэх жилдээ үйл ажиллагаа явуулж байна.





ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ




Жилд нийт **2.5 сая ширхэг** бэлэн бүтээгдэхүүн

КОМПАНИЙН ГЭРЧИЛГЭЭ



Бид дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн Монгол ноолууран бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэдээ хүргэхийн тулд Монгол Улсын төдийгүй олон улсын стандартын шаардлагыг хангаж, удирдлагын тогтолцоогоо тасралтгүй сайжруулж байна.



БРЭНДИЙН БҮТЭЦ



ГОВЬ ХК


GOBI


GOBI

Бүх насныханд зориулсан сонгодог загварын хувцас, аксессуар болон гэр ахуйн бүтээгдэхүүнээр дэлхийд танигдсан **GOBI** брэнд

GOBI
ORGANIC

Байгалийн үндсэн дөрвөн өнгийн ноолуурыг химийн будаг болон цайруулагч ашиглалгүйгээр урласан **GOBI ORGANIC** брэнд

GOBI
KIDS

Хүүхдийн хөдөлгөөнд саад учруулахгүйгээр дулаахан, таатай, хөнгөн мэдрэмжийг бэлэглэх загварлаг үрсийн **GOBI KIDS** брэнд


GOYO
CASHMERE

Орчин үеийн загварын чиг хандлагад нийцүүлэн бүтээлээ урладаг, тод өнгө, загваруудаар эрх чөлөөт байдлыг илэрхийлсэн шинэ залуу үеийн **GOYO** брэнд


YAMA
cashmere by GOBI

Дэлхийн шилдэг дизайнерууд ур ухаанаа шингээн урласан дээд зэргийн чанартай, тансаг зэрэглэлийн **YAMA** брэнд

БИДНИЙ АМЖИЛТ, ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД



I улиралд



4 жил тутам зохион байгуулагддаг өвлийн Тусгай Олимпод оролцох Монгол Улсын багаа дэмжин ноолууран бүтээгдэхүүнийхээ дээжээр гоёлоо.



Санхүүгийн Зохицуулах Хорооноос 2024 оны жилийн эцсийн байдлаар засаглалын кодексийн хэрэгжилтийг үнэлэхэд Говь ХК нь 98.6%-ийн үнэлгээ авч, нээлттэй хувьцаат компаниудаа дахин тэргүүллээ.




Тогтвортой хөгжлийн зарчмуулыг хэрэгжүүлж хариуцлагатай үйлдвэрлэл эрхлэх зорилгоор "Монголын Тогтвортой Санхүүгийн Холбоо"-нд гишүүнээр элслээ.



Аялал жуулчлалын улирлын нээлтийн арга хэмжээ болон загварын шоу-го зохион байгуулж хөтөч, жолооч, аяллын компаниудын төлөөлөл бүхий нийт 251 зочинд хамтран ажиллах төлөвлөгөөгөө танилцуулж мэдээлэл хүргэв.



"ГОВЬ" брэндийн шинэ салбар Чингис Хаан ОУНБ-ын 2 дугаар давхарт, зорчигчдын хүлээлгийн танхимд нээгдлээ. Энэхүү салбар нь Монгол ноолуурыг олон улсад таниулах, мөн чанартай, дээд зэргийн бүтээгдэхүүнийг аялагчдад хүргэх шинэ боломжийг бий болгож байна.




САНХҮҮ, ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН




БОРЛУУЛАЛТ



БОРЛУУЛАЛТ, ЦЭВЭР АШИГ /тэрбум төгрөг/



БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО, СЕГМЕНТЭЭР /тэрбум төгрөг, %/



САНХҮҮГИЙН ҮР ДҮН



ҮЗҮҮЛЭЛТ	Хэмжих нэгж	2024.03.31	2025.03.31		
		Гүйцэтгэл	Гүйцэтгэл	Өмнөх оноос өөрчлөлт	
				Тоо	Хувь
БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО	сая.төг	35,588	38,323	2,734	8%
Үүнээс: Дотоод борлуулалт	сая.төг	27,478	32,632	5,153	19%
Экспорт борлуулалт	сая.төг	4,148	1,723	(2,425)	-58%
Гадаад борлуулалт	сая.төг	3,962	3,968	6	0%
Борлуулсан бүтээгдэхүүний тоо ширхэг	мян.ширхэг	132	129	(2)	-2%
БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨРТӨГ	сая.төг	19,554	20,750	1,196	6%
НИЙТ АШИГ	сая.төг	16,034	17,572	1,538	10%
Нийт ашгийн хувь	хувь	45%	46%		1%
Үйл ажиллагааны зардал	сая.төг	15,397	17,574	2,178	14%
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ	сая.төг	637	(2)	(639)	-100%
Үйл ажиллагааны ашгийн хувь	хувь	2%	0%		-2%
Үйл ажиллагааны бус орлого (зардал)	сая.төг	(126)	(1,088)	(962)	-763%
Санхүүжилтийн зардал	сая.төг	7,204	6,304	(900)	-12%
Татварын өмнөх ашиг (алдагдал)	сая.төг	(6,693)	(7,394)	(701)	-10%
ЦЭВЭР АШИГ	сая.төг	(6,691)	(7,716)	(1,025)	-15%
Цэвэр ашгийн хувь	хувь	-19%	-20%		-1%
ҮЙЛДВЭРЛЭЛ	мян.ширхэг	219	226	7	3%
Сүлжмэл бүтээгдэхүүн	мян.ширхэг	138	148	10	7%
Нэхмэл бүтээгдэхүүн	мян.ширхэг	74	72	(2)	-2%
Оёмол бүтээгдэхүүн	мян.ширхэг	8	6	(1)	-14%
Үүнээс: Пальто	мян.ширхэг	4	4	0	4%
Пиджак	мян.ширхэг	1	0	(1)	-67%
Ээрмэл утас	тонн	53	49	(3)	-6%
АЖИЛТНУУДЫН ТОО	хүн	1,716	1,486	(230)	-13%
Нэг ажилтанд ногдох орлого	сая.төг	21	27	6	28%
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	сая.төг	7,736	204	(7,532)	-97%
Нийт өр төлбөр	сая.төг	339,832	325,001	(14,831)	-4%
Банкны зээл	сая.төг	304,766	250,908	(53,858)	-18%
Нийт хөрөнгө	сая.төг	337,395	314,009	(23,386)	-7%
Бараа материал	сая.төг	160,204	131,935	(28,270)	-18%
Маркетинг	сая.төг	2,377	1,953	(423)	-18%
Үүнээс: Гадаад маркетинг	сая.төг	1,709	1,090	(619)	-36%

САНХҮҮЖИЛТИЙН МЭДЭЭЛЭЛ



Санхүүжүүлэгчийн нэр	Валют	Дуусах хугацаа	2024.12.31		2025.03.31	
			(мян.валют)	(мян.төг)	(мян.валют)	(мян.төг)
Банкны зээл						
Голомт банк (Урт хугацаат зээл)	MNT	2025	-	3,333,333	-	833,333
Голомт банк (Зээлийн шугам)	MNT	2026	-	-	-	21,100,000
Голомт банк (Богино хугацаат зээл)	MNT	2025	-	9,300,000	-	9,000,000
Голомт банк (Богино хугацаат зээл)	MNT	2025	-	10,400,000	-	10,100,000
Хас банк (Зээлийн шугам)	MNT	2026	-	36,210,000	-	40,000,000
Хас банк (Богино хугацаат зээл)	MNT	2025	-	8,333,333	-	3,333,333
Азийн хөгжлийн банк (ADB)	USD	2026	\$ 14,400	49,251,600	\$ 14,400	50,227,344
Азийн хөгжлийн банк (ADB)	USD	2026	\$ 9,600	32,834,400	\$ 9,600	33,484,896
Олон Улсын Хөрөнгө Оруулалтын банк (IIB)	EUR	2027	€ 8,000	28,535,840	€ 8,000	30,119,680
Олон Улсын Хөрөнгө Оруулалтын банк (IIB)	EUR	2027	€ 14,000	49,937,720	€ 14,000	52,709,440
Нийт /Банкны зээл/				228,136,227		250,908,026
Бондын санхүүжилт						
Бонд (Богино хугацаат зээл) *	USD	2025	\$ 3,250	11,115,813	\$ 3,250	11,336,033
Нийт санхүүжилт				239,252,039		262,244,059

* Говь ХК нь “Говь Бонд 2” санхүүжилт татах ажлын хүрээнд 2024 оны 04-р сарын 23-ны өдөр эрх бүхий байгууллагын тогтоолоор хаалттай хүрээнд эргэлтийн хөрөнгө, дахин санхүүжилт, хөрөнгө оруулалт хийх зорилгоор 12 сарын хугацаатай, жилийн 8.5%-ийн купонтой 16,800,000 ам.долларын бонд гаргах зөвшөөрөл авсан бөгөөд 2025 оны 03-р сарын 31-ний өдрийн байдлаар 3,250,000 ам.долларын бондыг хөрөнгө оруулагчдаас татсан байна.


Монгол банкны ханш /төг/

	2024.12.31	2025.03.31
USD	3,420.25	3,488.01
EUR	3,566.98	3,764.96

ДОТООД ЗАХ ЗЭЭЛ




БОРЛУУЛАЛТ
32.6
тэрбум төгрөг




2025 оны 1-р улирлын байдлаар дотоод зах зээл 32.6 тэрбум төгрөгийн борлуулалттай ажиллаж өмнөх оны мөн үеэс 19% өсөлтийг үзүүлэв.

БОРЛУУЛАЛТЫН БҮТЭЦ



Дотоод зах зээлийн борлуулалтыг бүтцээр нь авч үзвэл жуулчдын борлуулалт үнийн дүнгээр 15%-ийг эзэлж байна.

БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН /мян.шир/



Борлуулсан бүтээгдэхүүний тоо ширхгийг нэр төрлөөр нь задалж харвал гутлын борлуулалт өмнөх оны мөн үеэс **433%** өссөн байна.

ДОТООД ЗАХ ЗЭЭЛ



I улиралд



Чингис Хаан Олон Улсын Нисэх
Буудалд "ГОВЬ" брэндийн шинэ
салбар нээгдэв.


2025.03




Аялал жуулчлалын улирлын нээлтийн арга хэмжээ
болон загварын шоуг зохион байгуулж хөтөч,
жолооч, аяллын компаниудын төлөөлөл бүхий нийт
251 зочинд хамтран ажиллах төлөвлөгөөгөө
танилцуулж мэдээлэл хүргэв.

2025.03


ГАДААД ЗАХ ЗЭЭЛ



ГАДААД ЗАХ ЗЭЭЛИЙН БОРЛУУЛАЛТЫН БҮТЭЦ



2025 оны 1-р улиралд нийт гадаад зах зээлд 5.7 тэрбум төгрөгийн борлуулалттай ажилласан. Үүнээс 30%-ийг экспортын борлуулалт, 70%-ийг гадаад борлуулалт эзэлж байна.



ВЕБСАЙТ

- EU**
- www.gobicashmere.com
 - www.gobicashmere.com/DE
 - www.gobicashmere.com/FR
 - www.gobicashmere.com/PL
- UK**
- www.gobicashmere.com/UK
- US**
- www.gobicashmere.com/US
- CN**
- www.gobicashmere.CN

ПЛАТФОРМ

- EU**
- Zalando: DE, AU, FR, SW
 - OTTO: DE
- US**
- Nordstrom
 - Macy's
- CN**
- TMALL, JD

САЛБАР ДЭЛГҮҮР

- DE**
- Berlin
 - Düsseldorf



GOBI × NP digital

ХАМТЫН АЖИЛЛАГАА

Гадаад борлуулалтын зах зээлд 2023 оноос эхлэн SEO буюу Search Engine Optimization компаниудтай хамтран ажиллаж брэндийн органик хайлтыг сайжруулах дээр анхааран үе шаттай арга хэмжээг аван ажиллаж байна.

2025 оны эхний улиралд:

30,000+

Characters бүхий text хэлбэрийн контент шинээр оруулсан

12+

Онлайн уулзалт, хурлуудыг зохион байгуулсан

20+

Task-ууд болон засваруудыг вебсайт дээр оруулсан

+21.1%

Органик хандалтын өсөлт

GOBI × M-Force

M-Force компани нь Японы маркетингийн шийдлээр мэргэшсэн байгууллага бөгөөд 2019 онд Казүки Нишигүчи тэргүүтэй мэргэжилтнүүдийн багийн санаачилгаар үүсгэн байгуулагдсан. Тус компани нь хэрэглэгчийн ойлголт, стратегийн төлөвлөлт, үр дүнгийн хэмжилт зэрэг чиглэлээр "**9 segs analyzer**" гэх үүлэн суурьтай хэрэгслийг санал болгодог бөгөөд энэ нь маркетингийн судалгааны салбарт шинэчлэл авчирсан.

2025 оны 02-р сараас эхлэн бид M-Force компанитай хамтран хэрэглэгчийн 9 сегментэд чиглэсэн стратегийн арга барилаа АНУ-ын зах зээлд эхлүүлсэн ба энэ нь хэрэглэгчийн ойлголт, сэтгэл хөдлөлийг төвлөрүүлсэн стратегийг ойлгож илүү гүнзгийрүүлэн ажиллах зорилготой.




I улиралд

2025.01.09

63%

АНУ-ын томоохон
маркетплейсүүдийн нэг
MACY'S-т Говь брэнд
нэгдлээ.

АНУ дахь нийт борлуулалтын
дүнгийн **63%** маркетплейс
дээр хийгдсэн.



2025 ОНЫ
ГУЛИРАЛД БИД





ПРОГРАММ ХӨГЖҮҮЛЭЛТ, ЦАХИМ ШИЛЖИЛТ








Компанийн хэмжээнд системийн шинэчлэлтийн ажлыг өргөжүүлэн INA-Manufacturing Execution System (MES) системийг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг 2024 оны 07-р сараас эхлүүлсэн бөгөөд **2025 оны 01-р сараас эхлэн** үйл ажиллагаандаа төлөвлөгөөний дагуу амжилттай нэвтрүүлэн, ашиглаж эхлээд байна.

- Санхүүгийн удирдлага сайжруулалт
- Үйл ажиллагааны үр ашиг нэмэгдэх
- Эрсдэлийг удирдах
- Бодит дүн шинжилгээ
- Нэгдсэн процесс



- Бүтээгдэхүүний зах зээлд нэвтрэх хугацаа богиносгох
- Бүтээгдэхүүний хөгжүүлэлт сайжрах
- Загварын түүхэн архив үүсэх





2025 оны I улиралд:

- Үндсэн **1**, капсул **4** коллекц
- Шинэ нэр төрлийн **2** бүтээгдэхүүнийг хэрэглэгчиддээ танилцуулав.

I улиралд хэрэглэгчдэд хүргэсэн коллекц, бүтээгдэхүүнүүд



LUNAR NEW YEAR 2025



GOBI S/S 2025



CashmereTECH



CASHMERE INSOLE



VALENTINE 2025



ОНЦЛОХ ЗАХИАЛГУУД



Ерөнхийлөгчийн тамгын газрын хүндэтгэлийн захиалгуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнээс дурдвал:

- Бүгд Найрамдах Польш Улсын Тэргүүн хатагтайн айлчлалын бэлэг,
- Шведийн Хаант Улсын Тэргүүн хатагтайн айлчлалын бэлэг,
- Монгол Улсын их хурлын даргын Их Британи Улс дахь айлчлалын бэлэг,
- Монгол Улсын Ерөнхий сайдын БНХАУ-ын Харбин хот дахь Азийн өвлийн спортын IX наадмын айлчлалын бэлэг.

ШИНЭЭР САНААЧИЛЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛУУД, ҮР ДҮН



- Үндсэн загварын 91 ширхэг загварын жагсаалт гарган сүлжмэлийн 33, оёмлын 7, нэхмэлийн 2 буюу нийт 42 ширхэг загвар дээр сайжруулалт хийсэн.
- 2025 онд 3D коллекцийн 8L, 15L шинэ загваруудын хөгжүүлэлтийн шинэ коллекц танилцуулсан.
- Free размерын оёмол пончо загварыг сайжруулан танилцуулж худалдаанд гаргасан.
- Valentine-25, Kids-F/W 25-26, ACC-25, 3D, Shoes 25, Silk Cashmere шинэ коллекц танилцуулсан.



ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД



- Улирлын чиг хандлага дагасан загваруудын борлуулалтыг дэмжих зорилгоор контент хөгжүүлэлт буюу дотоод борлуулалтын багтай хамтран зураг авалт хийгдэж байгаа ба дизайнерууд шинэ дүр төрхийг бүрдүүлэн ажиллаж байна.

- CashmereTECH, гутал болон бусад аутсорсинг бүтээгдэхүүний загвар технологи сайжруулах зорилгоор гадаадын үйлдвэрүүдтэй уулзалт хийсэн.



- Компанийн шигшээ багт зориулсан Gobi Sport Uniform загвар хөгжүүлэлт дээр ажилласан.



I улиралд

24

GOBI SS, Poncho, No photo ecommerce & flat standard, gobi.mn, Women's day PO, LTO, Puffer Jacket, Sale zone

Rebranding, Package, In-Store communication, Auxiliary materials,

КОЛЛЕКЦИ БОЛОН ИДЭВХИЖҮҮЛЭЛТ ЗУРАГ АВАЛТ

VISUAL COMMUNICATION

15


No Photo, SS Collections CN & EU, gobi.mn, Organic FW, EU Basics

5 concept ads, Annual Report, Traceability, Newsletters, Digital Ads

582

СТАНДАРТ ЗУРАГ АВАЛТ

ГРАФИК ЗАХИАЛГАТ АЖЛУУД



ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ





ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН УДИРДЛАГА



2024 оны Байгаль орчин, нийгэм, засаглалын тайланг бэлтгэн Монголын Хөрөнгийн Биржид хүргүүлэв.




ЯОУХАБ /JICA/-аас Монголын эрчим хүчний нөхцөл байдалд үндэслэн, эрчим хүчний нийлүүлэлт болон нүүрс төрөгчийг бууруулсан зохистой тэнцвэр буй болгоход чиглэсэн судалгаанд хөнгөн үйлдвэрлэлийн салбарыг төлөөлж оролцов.



Монгол улсын эдийн засаг дахь ноолуурын салбарын оролцоо, нөлөөллийн тухай судалгаа хийж буй Колумбын их сургуулийн судалгааны багтай хамтран ажиллав.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу улирал бүр агаарын шинжилгээг MNS:4585 стандартын дагуу 5 цэгээс хийгдэв.

MNS:4585



БАЙГАЛЬ ОРЧИН



"Эрчим Хүч Хэмнэлтийн Тухай Хууль"-ийн дагуух үүргээ биелүүлэн 2024, 2025 оны эрчим хүч хэмнэлтийн тайлан, төлөвлөгөөг боловсруулж "Эрчим Хүчний Зохицуулах Хороо"-нд хүргүүлэв.



Говь ХК-ийн байгаль орчны хуулийн нийцэл болоод тогтвортой хөгжлийн зорилгын хүрээнд хийсэн томоохон хөрөнгө оруулалтуудын нэг болох үйлдвэрийн хаягдал ус урьдчилан цэвэрлэх байгууламж шинээр барих төслийн ажил үргэлжилж байна.

221.7кг



Хог хаягдлын менежментийн хөтөлбөрийг хэрэгжүүлж, хуванцар дахин боловсруулах үйлвдэр TML PLASTIC ХХК-д ангилан ялгасан 221.7 кг хуванцар савыг тээвэрлүүлэв.



STeP EcoLab

Монголын текстилийн салбарын тогтвортой үйлдвэрлэл ба эко тэмдэг төсөл /STEP-ECOLAB/-ийн 2-р үеийн нээлтийн арга хэмжээнд оролцож, төслийн цаашдын хэрэгжүүлэлттэй холбоотой уулзалтыг төслийн багтай хийв.

ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

НИЙГЭМ



Тогтвортой ноолуур гурван талт төслийн хүрээнд хамрагдаж буй малчдын бүлгүүдээс 2025 оны ноолуурын чанарын үнэлгээ хийх зорилгоор дээж авах ажил амжилттай зохион байгуулагдлаа.



"Оролцогч талуудын хамтын ажиллагааны удирдлагын төлөвлөгөө"-ний хүрээнд Special Olympics-д оролцох Монголын тусгай Олимпын Хорооны баг тамирчдыг бараа бүтээгдэхүүнээр ивээн тэтгэв.



Монголын Тусгай Олимпын Хорооны баг тамирчид компанийн үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцаж, үндэсний ноолуурын салбарын технологи, үйлдвэрлэлийн шат дамжлагыг газар дээр нь үзэж сонирхон хамтын ажиллагааг дэмжих хөтөлбөр болон хөгжөөнт тоглоомуудад оролцов.





УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО



Олон улсын **"OEKO-TEX STANDARD 100"** бэлэн бүтээгдэхүүний гэрчилгээг сунгах ажлын хүрээнд **сүлжмэл, нэхмэл, оёмол** бүтээгдэхүүнийг хамруулахаар шаардагдах баримт бичиг болон мэдээллийг бүрдүүлэх, дээжийг шинжилгээнд явуулан ажиллаж байна.



"Цэвэр ноолуур боловсруулах зохистой дадал" тохирлын гэрчилгээний аудитад амжилттай оролцож, **Алтан гэрчилгээг** хүлээн авлаа.





ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

- "Эрсдэлийн хүлээн зөвшөөрөх түвшинд үйл ажиллагааг зохион байгуулах" зорилтын хүрээнд олон улсын практикт ашиглагдан түгээмэл болсон COSO ERM Framework – Integrated with Strategy and Performance тогтолцоог ISO 31000:2018 стандарттай хослуулан хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. COSO ERM Framework тогтолцоо нь байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааны эрсдэлийг илрүүлж удирдахаас илүүтэйгээр урт хугацааны зорилгод хүрэхийн тулд стратегийн түвшний гол эрсдэлийг тодорхойлж, удирдах давуу талтай.
- 2025 оны 1-р улиралд:
 - "Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх журам"-г шинэчлэн боловсруулав.
 - "Эрсдэлийн хүлээн зөвшөөрөх түвшний баримт бичиг"-г боловсруулав.
 - Эрсдэлийн үнэлгээний маягтуудыг шинэчлэн боловсруулав. (Үүнд: Эрсдэлийн чанарын шинжилгээний маягт, Тоон шинжилгээний маягт, Хариу арга хэмжээ төлөвлөлтийн маягт, Эрсдэлийн аппетитын гүйцэтгэлийн маягт)
 - "Эрсдэлийн үнэлгээ, хариу арга хэмжээний төлөвлөлт хийх гарын авлага"-ыг боловсруулав.

2025 оны 2-р улирлаас тайлагналын урсгалын дагуу эрсдэлийн аппетитын гүйцэтгэлийг улирал бүр хянах, өндөр түвшинд байгаа эрсдэлд хариу арга хэмжээ төлөвлөж, төлөвлөгөөний гүйцэтгэлд хяналт тавин ажиллана.

ШҮГЭЛ ҮЛЭЭХ СИСТЕМ

Эх сурвалж	Шүглийн тоо
Шүгэл үлээх системээр	12
Утсаар	5
Бусад сувгаар	5
НИЙТ	22

ЖУРМЫН НИЙЦЭЛ

Ач холбогдол


Хэрэгжилтийг хянах

Хууль эрх, зүйн нийцлийг хангуулах

Чиг үүргийн давхардлыг арилгах

Бүтээмжийг дээшлүүлэх

Гүйцэтгэл



■ Нийцэл хийгдсэн ■ Хүлээгдэж байгаа

ХӨДӨЛМӨРИЙН ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ БАЙДАЛ



ЗОРИЛТ: ОСОЛ-О БАЙХ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧИНГҮЙ БАЙЖ, АЖИЛТНУУДЫН ЭРҮҮЛ МЭНДИЙГ ХЭВЭЭР ХАДГАЛАХ, ЧАНАРЖУУЛАХ

Хугацаа алдсан гэмтлийн давтамж	Тохиолдлуудыг *1,000,000 Ажилласан хугацаа /цаг/	LTI-давтамж
	0*1,000,000/6,385,200 хүн/ц	0.0

Хугацаа алдсан гэмтэлгүй ажилласан өдөр:	481 өдөр /1,650 ажилтнаар/
Хугацаа алдсан гэмтэлгүй ажилласан цаг:	7,863,600 хүн/ц
Тоолж эхэлсэн огноо:	2023.05.12
Сүүлийн огноо:	2025.03.31

ХӨДӨЛМӨРИЙН ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СУРГАЛТ

Монгол Улсын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд заасны дагуу хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын ерөнхий мэдлэгийн болон эрх олгох сургалтуудыг амжилттай зохион байгууллаа.

2025 оны 03-р сарын 30-ны байдлаар нийт давхардсан тоогоор нийт **516** ажилтанд, **1,844 хүн/цаг** сургалт орсон.



ХӨДӨЛМӨРИЙН ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ БАЙДАЛ



Ноолуур татан авалтын үед ажилтнуудыг хачигт халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор анхан шатны үйлдвэр, түүхий эдийн нярав, чанар баталгаажуулалт, жолооч, лабораторийн ажилтнуудыг хачгийн вакцинд хамруулах ажил үргэлжлэн хийгдэж байна.



Говь ХК-ийн Үйлдвэрчний эвлэл Уламжлалт анагаах ухааны төв хүрээлэнтэй хамтран 2025 оны 02-р сард эмчилгээ, сувилгаа шаардлагатай ажилтнуудаа эмийн бус эмчилгээнд хамруулан эрүүлжүүлэн чийрэгжүүлэх зорилгоор **60 ажилтнаа** Улаанбаатар рашаан сувилалд хэвтүүлэн сувилуулсан.



Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургуулилыг 03-р сарын 27-ны өдөр амжилттай зохион байгуулсан.



Ажилтны амь нас, эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр үйлдвэрийн орчны хяналтыг Химийн бодисын хяналт, Өндөр эрсдэлтэй ажилбарын хяналт, өдөр тутмын хяналт, гал болон тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны хяналтыг тогтмол тавьж ажиллаж байна.



Ажилтнуудынхаа эрүүл мэндийг дэмжих зорилгоор 1 улиралд давхардсан тоогоор **146 ажилтанд 1,305 ширхэг** эрдэс нөхөх бүтээгдэхүүн олгов.



03-р сард ажилтнуудын эрүүл мэндийг дэмжих, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “Витаминжуулалтын аяныг зохион байгуулсан.

ХҮНИЙ НӨӨЦ



Нийт ажилтны тоо:



1,486



Эрэгтэй – **31%**
Дундаж нас: **32**



Эмэгтэй - **69%**
Дундаж нас: **37**


Байршлаар:




Монгол - 1,471 (99%)

- Улаанбаатар хот **1,440**
- Дархан **3**
- Хэнтий **27**

Ажилласан жилээр:



- 20-с дээш жил
- 10-20 жил
- 6-10 жил
- 2-6 жил
- 0-2 жил



Олон улс – 15 (1%)

- АНУ **1**
- Европ **14**



СУРГАЛТ ХӨГЖИЛ

1 АЖИЛТАНД НОГДОХ
СУРГАЛТЫН ХҮН ЦАГ



0.43 хүн/цаг

НИЙТ СУРГАЛТЫН
ЗАРДЛЫН
ЗАРЦУУЛАЛТ



36.6 сая

СУРГАЛТЫН ТОО

29

СУРГАЛТАД
ХАМРАГДСАН
АЖИЛТНЫ ТОО

786

Гадаад орны сургалт

- 1 удаагийн сургалт
- 2 ажилтан
- Зардал: 20.3 сая төгрөг

Гадны байгууллагын
сургалт

- 2 удаагийн сургалт
- 52 ажилтан
- Зардал – 0 төгрөг

Дотоод сургалт

- 25 удаа сургалт орсон
- 727 ажилтан хамрагдсан
- Зардал 0 төгрөг

Scholarship
хөтөлбөрийн сургалт

- Бакалаврын зэргийн 4 жилийн сургалт
- 5 ажилтан хамрагдсан
- Зардал 16,275,000 төгрөг

ХҮНИЙ НӨӨЦ



ИДЭВХЖҮҮЛЭЛТ БОЛОН ОЛОН НИЙТИЙН АЖЛУУД



ГОВЬ СПОРТ КОМПА-2025
ЗОХИОН БАЙГУУЛЛАА



ТАВАН БОГД ГРУППЫН СПОРТ
КОМПА-Д ОРОЛЦЛОО



ШИЛДГҮҮДЭЭ ТОДРУУЛАХ
ЁСЛОЛЫН АРГА ХЭМЖЭЭ
ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА



НИЙТ 233 ХҮНД ҮЙЛДВЭР
ТАНИЛЦУУЛАХ АЯЛЛЫГ
ЗОХИОН БАЙГУУЛЛАА.




МЭРГЭЖЛИЙН БАХАРХАЛТ
ӨДӨР
ДЭЛХИЙН ЭМЧ НАРЫН ӨДӨР



АЖИЛТНУУДАД ЗОРИУЛСАН
БАРИА ЗАСЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ




ӨНДӨР НАСТНУУДАД ГАРЫН
БЭЛЭГ ГАРДУУЛЛАА



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ



НИЙТ ГАРГАСАН
ХУВЬЦААНЫ ТОО
780,112,500

НИЙТ ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ТОО
25,437

2025.03.31-ний байдлаар

НӨЛӨӨ БҮХИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ

Хувьцаа эзэмшигчийн нэр	2024.12.31		2025.03.31	
	Хувьцааны тоо ширхэг	Эзэмшлийн хувь	Хувьцааны тоо ширхэг	Эзэмшлийн хувь
Таван Богд Холдингс ХХК	681,267,736	87.33%	681,267,736	87.33%

Тайлант хугацаанд нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн бүтцэд өөрчлөлт ороогүй.

ТУЗ-ИЙН ГИШҮҮД



ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮД



Д.ГЭРЭЛМАА

*Нэр дэвшүүлэх хорооны дарга,
Эрсдэл, аудитын хорооны
гишүүн*

СЭЗИС, Бизнес удирдлагын
тэнхимийн профессор



Д.ХҮРЭЛБААТАР

*Цалин урамшууллын
хорооны дарга,
Нэр дэвшүүлэх хорооны
гишүүн*



Б.ЦЭЭНЯМ

*Цалин, урамшууллын
хорооны гишүүн*

Anand Resource LLC,
Ерөнхий менежер



А.ЖАРГАЛМАА

*Эрсдэл, аудитын
хорооны дарга*

GAPF, ACCA ахлах багш,
хөтөлбөрийн удирдагч

ТУЗ-ИЙН ЕРДИЙН ГИШҮҮД



Ц.БААТАРСАЙХАН

*ТУЗ-ийн дарга,
Нэр дэвшүүлэх хорооны гишүүн*

Таван Богд Группийн
Ерөнхийлөгч



Ц.ОРГИЛБОЛД

Говь Кашмер Европ ХХК-ийн
Гүйцэтгэх захирал



Д.ХУЛАН

*Цалин, урамшууллын
хорооны гишүүн*

Таван Богд Группийн
ТУЗ-ийн дарга



Н.МӨНХБАТ

*Эрсдэл, аудитын
хорооны гишүүн*

Таван Богд Холдингс ХХК-ийн
Санхүү удирдлага хариуцсан
захирал



Б.АМАРСАЙХАН

Говь ХК-ийн Гүйцэтгэх
захирал

ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙН БҮРЭЛДЭХҮҮНД ОРСОН ӨӨРЧЛӨЛТ

2025.02.01-ний өдрөөс эхлэн
ТУЗ-ийн даргаар
Ц.Баатарсайхан томилогдов.



Гүйцэтгэх захирал
Б.АМАРСАЙХАН



Дизайн,
үйлдвэрлэл
хариуцсан
дэд захирал
Б.БОЛОРМАА



Санхүү
удирдлага
хариуцсан
захирал
Б.ХАНГАЛАН



Гадаад
борлуулалт
хариуцсан
захирал
Г.АНУДАРЬ



Хүний нөөц
хариуцсан
захирал
Т.ИЧИНХОРЛОО



Мэдээлэл
технологи
хариуцсан
захирал
Б.ЭРДЭНЭ



Бүртгэлийн
газрын
захирал
Д.СОДГЭРЭЛ



Дизайн
хөгжүүлэлтийн
газрын захирал
А.УЧРАЛ




Комплайнсын
газрын
захирал
Б.ЧИНГҮҮН

ХУВЬЦААНЫ ХАНШ



Говь ХК-ийн зах зээлийн үнэлгээ **2025.03.31**-ний өдрийн хаалтын ханшаар **186.4**тэрбум төгрөг байна.
Нэгж хувьцааны дундаж ханш **251.71** төгрөг (▼3.6%)

ҮЗҮҮЛЭЛТ	2024.12.31	2025.03.31	Өөрчлөлт %
ХУВЬЦААНЫ ҮНЭ /төгрөг/			
Хаалтын үнэ	258.00	239.00	-7.4%
Хамгийн их үнэ	283.98	269.40	-5.1%
Хамгийн бага үнэ	245.06	234.90	-4.1%
Дундаж үнэ	261.24	251.71	-3.6%
АРИЛЖААЛАГДСАН ТОО /ширхэг/			
Хамгийн их /өдөрт/	257,495,975	136,084	-99.9%
Хамгийн бага /өдөрт/	322	1,167	262.4%
Дундаж /өдөрт/	1,078,172	17,608	-98.4%
Нийт	269,543,096	1,074,081	-99.6%
АРИЛЖААНЫ ҮНИЙН ДҮН /төгрөг/			
Хамгийн их /өдөрт/	65,661,782,758	33,759,555	-99.9%
Хамгийн бага /өдөрт/	85,264	297,874	249.4%
Дундаж /өдөрт/	275,011,411	4,431,836	-98.4%
Нийт	68,752,852,703	270,341,986	-99.6%
ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ /төгрөг/	201,269,025,000	186,446,887,500	-7.4%



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТ



№	Гарчиг	2023.12.31		2024.12.31	
		СЗХ-ны хяналтын оноо	Хэрэгжилт хувь	СЗХ-ны хяналтын оноо	Хэрэгжилт хувь
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	11	91.7%	12	100.0%
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	9	90.0%	9	90.0%
3	Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6	100.0%	6	100.0%
4	Аудит, хяналтын тогтолцоо	6	100.0%	6	100.0%
5	Эрсдэлийн удирдлага	8	100.0%	8	100.0%
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	100.0%	6	100.0%
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	100.0%	8	100.0%
8	Компанийн соёл	6	100.0%	6	100.0%
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	100.0%	9	90.0%
Нэгдсэн дүн		70	97.2%	71	98.6%

Говь ХК-ийн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг СЗХ-ноос 2024 оны хагас жил болон жилийн эцсээр 2 удаа үнэлэхэд **98.6% болж 1.4% өссөн буюу засаглал хэвийн, эрсдэлгүй** гэж үнэлэгдсэн. Энэ нь 2023 оны жилийн эцсийн үнэлгээнээс 1.4% өссөн үзүүлэлт бөгөөд бид Монгол улс дахь нээлттэй хувьцаат компаниуд дундаас эхний байранд давтан үнэлэгдсэн.

Засаглалын үнэлгээний дэлгэрэнгүй тайлантай Монголын Хөрөнгийн Бирж болон компанийн цахим хуудаснаас, мөн [энд дарж](#) танилцах боломжтой.



GOBI

АНХААРАЛ ХАНДУУЛСАНД
БАЯРЛАЛАА

Хагас жил, улирлын үйл ажиллагааны тайлан /маягт 2/	
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.	
Тайлагнах хугацаа	2025 оны 01-р сарын 01-ний өдрөөс 2025 оны 03-р сарын 31-ний өдөр
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	Компанийн нэр: “Говь” ХК УБГД: 9010001061 Үнэт цаасны код: MN00GOV03548 Албан ёсны хаяг: Монгол улс, Улаанбаатар хот-17062, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрийн гудамж, Говь ХК Утасны дугаар: (+976) 7013-9977 Факс: (976)-70143081 И-мэйл: info@gobicashmere.com Веб сайт: info.gobi.mn Фейсбүүк: GobiCashmere Онлайн дэлгүүр: Дотоод: gobi.mn Гадаад: gobicashmere.com
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын Хөрөнгийн Бирж
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Ямааны ноолуурт цогц боловсруулалт хийж, бүтээгдэхүүн үйлдвэрлэн борлуулах
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	780,112,500
Хагас жил, улирлын тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Улирлын тайланг бэлтгэсэн мэргэжилтэн: М.Сэлэнгэ /ТУЗ-ийн нарийн бичгийн дарга/ Хянасан: Б.Амарсайхан /Гүйцэтгэх захирал/
1.	Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/

1.1.	Санхүүгийн байдлын үзүүлэлт		
	"ГОВЬ" ХУВЬЦААТ КОМПАНИ БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН		
		(мян.төг)	
		2024.12.31	2025.03.31
	ХӨРӨНГӨ		
	Эргэлтийн хөрөнгө		
	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	4,326,046	3,846,934
	Дансны ба бусад авлага	3,512,304	7,194,317
	Урьдчилгаа төлбөр	9,404,878	6,774,589
	Бараа материал	122,708,175	131,934,527
		139,951,403	149,750,367
	Эргэлтийн бус хөрөнгө		
	Үндсэн хөрөнгө	153,147,719	149,400,380
	Ашиглах эрхтэй түрээсийн хөрөнгө	2,780,438	3,901,300
	Хойшлогдсон татварын хөрөнгө	5,661,214	5,351,572
	Бусад эргэлтийн бус хөрөнгүүд	4,736,726	5,605,223
		166,326,098	164,258,475
	Нийт хөрөнгийн дүн	306,277,501	314,008,842
	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
	Богино хугацаат өр төлбөр		
	Дансны ба бусад өглөг	37,867,812	43,385,220
	Гэрээний өр төлбөр	2,129,778	1,904,794
	Богино хугацаат түрээсийн өглөг	1,103,295	1,226,668
	Орлогын албан татварын өглөг	381,026	163,663
	Богино хугацаат зээл	211,265,887	261,988,191
		252,747,798	308,668,536
	Урт хугацаат өр төлбөр		
	Урт хугацаат түрээсийн өглөг	1,922,734	2,392,797
	Урт хугацаат зээл	36,210,000	-
	Бусад урт хугацаат өглөг	-	-
	Хойшлогдсон татварын өглөг	13,939,844	13,939,844
		52,072,578	16,332,641
	Нийт өр төлбөрийн дүн	304,820,376	325,001,177
	Эзэмшигчдийн өмч		
	Хувьцаат капитал	780,113	780,113
	Дахин үнэлгээний нэмэгдэл	43,777,386	43,777,386
	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	(12,119,789)	(16,852,850)
	Хуримтлагдсан алдагдал	(30,980,585)	(38,696,984)
		1,457,125	(10,992,335)
	Нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн	306,277,501	314,008,842

1.2.	Орлогын тайлан		
"ГОВЬ" ХУВЬЦААТ КОМПАНИ БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД НЭГТГЭСЭН ИЖ БҮРЭН ОРЛОГЫН ТАЙЛАН			
			(МЯН.ТӨГ)
		2024.12.31	2025.03.31
Борлуулалтын орлого		247,026,317	38,322,514
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг		(138,552,341)	(20,750,018)
Нийт ашиг		108,473,976	17,572,496
Бусад орлого		3,649,691	210,686
Борлуулалт ба маркетингийн зардал		(53,217,129)	(11,359,280)
Ерөнхий ба удирдлагын зардал		(24,908,151)	(6,298,845)
Бусад зардал		(6,919,419)	(1,220,005)
Санхүүгийн орлого		4,465,583	5,349
Санхүүгийн зардал		(33,118,100)	(6,303,932)
Татварын өмнөх алдагдал		(1,573,549)	(7,393,530)
Орлогын татварын өгөөж (зардал)		(2,083,660)	(322,869)
Тайлант жилийн цэвэр алдагдал		(3,657,209)	(7,716,399)
Ашиг, алдагдал руу дараа үед дахин ангилагдах боломжтой бусад дэлгэрэнгүй орлого:			
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нөлөөлөл		32,341,972	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний татварын нөлөөлөл		(8,085,493)	-
Гадаад дахь охин компаниудын цэвэр хөрөнгийн гадаад валютын ханшийн хөрвүүлэлтийн зөрүү		(1,457,515)	(4,733,061)
Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй (алдагдал) орлого		22,798,964	(4,733,061)
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй алдагдал		19,141,755	(12,449,460)

1.3.	Өмчийн өөрчлөлтийн тайлан					
	"ГОВЬ" ХУВЬЦААТ КОМПАНИ БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД НЭГТГЭСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН					(мян.төг)
	Хувьцаат капитал	Дахин үнэлгээний нөөц	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Нийт	
	2024 оны 01 сарын 01-ний үлдэгдэл	780,113	20,514,269	(10,662,273)	(28,316,738)	(17,684,629)
	Тайлант жилийн цэвэр алдагдал	-	-	-	(3,657,209)	(3,657,209)
	Бусад дэлгэрэнгүй орлого	-	24,256,479	(1,457,516)	-	22,798,963
	Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй алдагдал	-	24,256,479	(1,457,516)	(3,657,209)	19,141,754
	Хуримтлагдсан ашиг уруу шилжүүлсэн	-	(993,362)	-	993,362	-
	2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	780,113	43,777,386	(12,119,789)	(30,980,585)	1,457,125
	Тайлант жилийн цэвэр алдагдал	-	-	-	(7,716,399)	(7,716,399)
	Бусад дэлгэрэнгүй алдагдал	-	-	(4,733,061)	-	(4,733,061)
	Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй алдагдал	-	-	(4,733,061)	(7,716,399)	(12,449,460)
	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
	2025 оны 03 сарын 31-ний үлдэгдэл	780,113	43,777,386	(16,852,849)	(38,696,984)	(10,992,335)
1.4.	Мөнгөн гүйлгээний тайлан					
	"ГОВЬ" ХУВЬЦААТ КОМПАНИ БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН					(мян.төг)
				2024.12.31	2025.03.31	
	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ			29,728,027	(16,310,663)	
	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ			(21,049,750)	(998,611)	
	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ			(12,361,396)	16,758,014	
	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ			(3,683,119)	(551,260)	
	Гадаад үйл ажиллагааг хөрвүүлсэн гадаад валютын ханшийн зөрүү			(1,457,516)	(4,733,061)	
	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			(24,430)	4,805,209	
	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл			9,491,111	4,326,046	

2.

Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэл, аудитын хорооны дүгнэлт

GOBI 

"ГОВЬ" ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ
ЭРСДЭЛ АУДИТЫН ХОРООНЫ
ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 04 сарын 18 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Г 2025 оны 1-р улирлын санхүүгийн тайланг дүгнэх тухай Г

Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан "Үнэт цаасны бүртгэлийн журам", Говь ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх "Эрсдэл, аудитын хорооны үйл ажиллагааны журам"-ын 3.1.1.1-р заалтыг тус тус үндэслэн Эрсдэл, аудитын хорооны хурлаас **ТОГТООХ** нь:

1. Говь ХК-ийн 2025 оны 1-р улирлын санхүүгийн тайлан нь холбогдох хууль, дүрэм, журам, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн болохыг хүлээн зөвшөөрч байгаа тул олон нийтэд мэдээлэхийг зөвшөөрсүгэй.
2. 1-р улирлын тайланг холбогдох журмын дагуу Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Бирж-д хүргүүлэн олон нийтэд тайлагнан ажиллахыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /М.Сэлэнгэ/-д үүрэг болгосугай.

2.

ЭРСДЭЛ, АУДИТЫН ХОРООНЫ ДАРГА
ГИШҮҮД



А.ЖАРГАЛМАА
Д.ГЭРЭЛМАА
Н.МӨНХБАТ

3.	Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт																					
3.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	<table border="1"> <thead> <tr> <th data-bbox="646 353 1050 405">Үзүүлэлт</th> <th data-bbox="1050 353 1249 405">2024.03.31</th> <th data-bbox="1249 353 1452 405">2025.03.31</th> </tr> </thead> <tbody> <tr> <td data-bbox="646 405 1050 443">Бохир ашгийн маржин</td> <td data-bbox="1050 405 1249 443">45%</td> <td data-bbox="1249 405 1452 443">46%</td> </tr> <tr> <td data-bbox="646 443 1050 481">Цэвэр ашгийн маржин</td> <td data-bbox="1050 443 1249 481">-19%</td> <td data-bbox="1249 443 1452 481">-20%</td> </tr> <tr> <td data-bbox="646 481 1050 519">Эргэлтийн харьцаа</td> <td data-bbox="1050 481 1249 519">0.6</td> <td data-bbox="1249 481 1452 519">0.5</td> </tr> <tr> <td data-bbox="646 519 1050 589">Бараа материалын эргэц</td> <td data-bbox="1050 519 1249 589">417</td> <td data-bbox="1249 519 1452 589">382</td> </tr> <tr> <td data-bbox="646 589 1050 627">Хувьцааны нэгж үнэ /₮/</td> <td data-bbox="1050 589 1249 627">267</td> <td data-bbox="1249 589 1452 627">239</td> </tr> </tbody> </table>			Үзүүлэлт	2024.03.31	2025.03.31	Бохир ашгийн маржин	45%	46%	Цэвэр ашгийн маржин	-19%	-20%	Эргэлтийн харьцаа	0.6	0.5	Бараа материалын эргэц	417	382	Хувьцааны нэгж үнэ /₮/	267	239
Үзүүлэлт	2024.03.31	2025.03.31																				
Бохир ашгийн маржин	45%	46%																				
Цэвэр ашгийн маржин	-19%	-20%																				
Эргэлтийн харьцаа	0.6	0.5																				
Бараа материалын эргэц	417	382																				
Хувьцааны нэгж үнэ /₮/	267	239																				
3.2.	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт																					
3.3.	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл	<ul style="list-style-type: none"> • 2025 оны 1-р улиралд борлуулалтын орлого өмнөх оны мөн үеэс 8%-аар өссөн. Нийт борлуулалтын 85%-ийг дотоод, 15%-ийг гадаад зах зээл эзэлж байна. • Бүтээгдэхүүний загварын тоог бууруулж, өмнө нь худалдаанд гарч байсан, эрэлт ихтэй загваруудын масс үйлдвэрлэлийг нэмэгдүүлсэн. Ингэснээр хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн өнгө, размерын сонголт нэмэгдсэн. • Дотоодын зах зээлд бүтээгдэхүүний үнийн бодлогыг шинэчлэн, ижил төстэй загвартай бүтээгдэхүүн хоорондын үнийн ялгааг бууруулахад анхаарч ажилласнаар хэрэглэгчид сонголт хийхэд хялбар болсон. Мөн социал маркетингийг 2-р сараас илүү идэвхтэй болгосон нь дотоодын худалдан авалтыг нэмэгдүүлэхэд нөлөөлсөн. 3-р сарын 1-нд Чингис Хаан Олон Улсын Нисэх Буудалд салбар дэлгүүрээ нээсэн. • Гадаад зах зээлд уламжлалт маркетингаас илүү дижитал маркетингийг илүү идэвхтэй ашиглаж, e-commerce борлуулалтыг дэмжих бодлого баримтлан ажиллаж байна. Мөн борлуулалтын сувгаа өргөжүүлж 1-р сараас АНУ-ын Macy's онлайн худалдааны платформоор бүтээгдэхүүнээ борлуулж эхэлсэн. • Дизайн хөгжүүлэлтийн хувьд CashmereTECH технологийн куртка, гутал болон бусад outsourcing бүтээгдэхүүний загвар технологийн сайжруулалт дээр анхаарч ажилласан. • Үйлдвэрлэлийн бүтээмжээ сайжруулах, өртгийг бууруулах хүрээнд 3D бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг 2 дахин нэмэгдүүлснээр илүү бага хөдөлмөрөөр чанартай бүтээгдэхүүнийг үйлдвэрлэдэг болсон. Мөн технологийн шинэчлэл хийж MES /Manufacturing Execution System/ болон дамжлагын системийг нэвтрүүлснээр үйлдвэрлэлийн удирдлага 																				

		<p>сайжирсан.</p> <ul style="list-style-type: none"> Говь ХК нь тогтвортой хөгжлийн зарчмуудыг хэрэгжүүлж, хариуцлагатай үйлдвэрлэл эрхлэх зорилгоор “Монголын Тогтвортой Санхүүгийн Холбоо”-нд гишүүнээр элссэн. Мөн “Тогтвортой хөгжлийн стратегийн бодлого”-оо батлан, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн Монгол ноолууран бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэдээ хүргэхийн тулд Монгол Улсын төдийгүй олон улсын стандартын шаардлагыг хангаж, удирдлагын тогтолцоогоо тасралтгүй сайжруулж байна.
3.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого	Санхүүгийн байдлын гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээ байхгүй.
4.	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/	
<p>ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЭЛ</p> <p>Тайлант хугацаанд их хэмжээний хэлцэл хийгээгүй.</p> <p>СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ</p> <p>Говь ХК-ийн “Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журам”-ын дагуу жил бүрийн эхэнд Компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай бараа, үйлчилгээг зах зээлийн үнэ, нөхцөлөөр худалдан авах болон худалдах хэлцэл хийхийг зөвшөөрсөн нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн жагсаалт болон хэлцлийн төсвийг ТУЗ-ийн хараат бус гишүүдийн дийлэнх олонхын саналаар баталдаг.</p> <p>Дээрх журмын дагуу батлагдсан жагсаалтад ороогүй этгээдтэй хийх болон батлагдсан төсвөөс хэтэрсэн сонирхлын зөрчилтэй хэлцлийг хийх бүрд тухайлсан тогтоолоор ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн зөвшөөрөл олгодог.</p> <p>ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хороо нь Компанийн хэмжээнд хийгдэж буй сонирхлын зөрчилтэй хэлцэл нь батлагдсан төсвийн хүрээнд, зах зээлийн үнэ нөхцөлөөр, хуулийн дагуу хийгдэж байгаа эсэх дээр улирал бүрийн хорооны хурлаараа дамжуулан тогтмол хяналт тавьж ажилладаг.</p> <p>2025 оны хувьд ТУЗ-ийн 2025 оны 03-р сарын 20-ны №07 тоот тогтоолоор тус зөвшөөрлийг олгосон.</p> <p>2025 оны 1-р улирлын сонирхлын зөрчилтэй хэлцлийн гүйцэтгэлтэй Эрсдэл, аудитын хорооны 2025 оны 04-р сарын 07-ны ээлжит хурал дээр танилцан, төсөвт тусгаагүй байсан хэлцэл дээр ТУЗ-ийн 2025 оны 04-р сарын 09-ний №15 тоот тогтоолоор зөвшөөрөл олгосон.</p>		

ХОЛБООТОЙ ТАЛУУДАЙ ХИЙСЭН ГҮЙЛГЭЭ

(мян.төг)

Холбоотой талуудтай хийсэн гүйлгээ	2024.03.31	2025.03.31
Холбоотой талд өгсөн санхүүжилт	184,284,048	-
Холбоотой талаас авсан санхүүжилт	187,307,000	-
Холбоотой талтай хийсэн борлуулалт	29,709	12,047
Холбоотой талаас авсан худалдан авалт	690,112	593,111
Хүүгийн орлого	-	-
Хүүгийн зардал	2,721,597	1,043,220
Түрээсийн орлого	67,185	148,305
Түрээсийн зардал	190,828	190,876


Жич: Холбоотой талууд гэдэгт Таван Богд Группийн охин компаниуд орсон болно.

5. Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл

Олон нийтэд санал болгон хувьцаа гаргаагүй.

6. Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ



НИЙТ ХУВЬЦААНЫ ТОО

780,112,500

НИЙТ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТОО

25,437

/2025.03.31-ний байдлаар/

Таван Богд Холдингс ХХК

НӨЛӨӨ БҮХИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ

Хувьцаа эзэмшигчийн нэр	2024.12.31		2025.03.31	
	Хувьцааны тоо ширхэг	Хувь	Хувьцааны тоо ширхэг	Хувь
Таван Богд Холдингс ХХК	681,267,736	87.33%	681,267,736	87.33%

Тайлант хугацаанд нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн бүтэц, хувьцааны эзэмшилд өөрчлөлт ороогүй.

КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ӨӨРЧЛӨЛТ

- ТУЗ-ийн 2025 оны 01-р сарын 31-ний өдрийн [№02 тоот](#) тогтоолоор ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмааг 2025 оны 01-р сарын 31-ний өдрөөр дуусгавар болгон өөрийн хүсэлтээр үүрэгт ажлаас чөлөөлж, 2025 оны 02-р сарын 01-ний өдрөөс эхлэн ТУЗ-ийн даргаар Ц.Баатарсайханыг томилов.

7. Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл

ТУЗ-ИЙН ХУРЛЫН МЭДЭЭЛЭЛ

Хурал	Ээлжит хурал	Ээлжит бус хурал	Цахим санал хураалт	Хэлэлцсэн асуудал	Шийдвэр	Санал зөвлөмж	Үүрэг даалгавар	Баталсан тогтоол
ТУЗ-ийн хурал	2	2	1	18	21	3	2	12
Эрсдэл, аудитын хорооны хурал	1	-	-	7	4	5	-	-
Нэр дэвшүүлэх хорооны хурал	1	-	2	10	9	2	5	4
Цалин урамшууллын хорооны хурал	1	-	-	6	7	2	1	1
Нийт	5	2	3	41	41	12	8	17

Говь ХК-ийн ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх хороод нь 2025 оны 1-р улирлын байдлаар нийт 5 ээлжит хурал, 2 ээлжит бус хурал, 3 цахим санал хураалт зохион байгуулж гишүүд идэвх санаачилгатай ажиллав.

ТУЗ-ИЙН ТОГТООЛ, ШИЙДВЭР

Тайлант хугацаанд ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх хороод нийт 41 асуудлыг хэлэлцэн, 41 шийдвэр гаргаж, 17 тогтоолыг баталсан. Үүнд:

- ТУЗ-өөс 12 тогтоол (дотоод үйл ажиллагаатай холбоотой 10 тогтоол, хүний нөөцтэй холбоотой 2 тогтоол)
- Нэр дэвшүүлэх хорооноос 4 тогтоол,
- Цалин, урамшууллын хорооноос 1 тогтоол.

Мөн чиг үүргийнхээ хүрээнд удирдлагуудад 12 санал зөвлөмж, 8 үүрэг даалгавруудыг өгч, хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллав. ТУЗ-ийн шийдвэр болон үүрэг даалгаврын биелэлт 100% хэрэгжилттэй байв.

НОГДОЛ АШИГ

Говь ХК-ийн ТУЗ-ийн 2025 оны 02-р сарын 07-ны өдрийн [№02 тоот](#) тогтоолын дагуу компанийн 2024 оны санхүүгийн үр дүн нь компанийн ногдол ашгийн бодлогын 2.3-т заасан ногдол ашиг олгох нөхцөлийг хангаагүй буюу санхүүгийн зохистой харьцааг хангахгүй байгаа тул ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн.

МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ, ТАЙЛАГНАЛ

1-р улирлын байдлаар дараах тайлан мэдээллийг хуулийн хугацаанд СЗХ болон МХБ рүү илгээн, олон нийтэд тайлагнан ажилласан.

- 2024 оны Жилийн үйл ажиллагааны тайлан;

- 2024 оны Аудитлагдсан санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт;
- 2024 оны Байгаль орчин, нийгэм, засаглалын үйл ажиллагааны тайлан;
- Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн тайлан (2024.12.31-ний байдлаар);
- Тухай бүр хүргэх мэдээллүүд.

ШИНЭЭР БАТЛАГДСАН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮД

2025 оны 1-р улиралд ТУЗ-өөс дараах бодлого, журмыг баталсан. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 1-р сарын Эрсдэл, аудитын хорооны хурлаар хэлэлцэн, ТУЗ-ийн 03-р сарын 20-ны №08 тоот тогтоолоор шинэчлэн баталсан.

Засаглалтай холбоотой дэлгэрэнгүй тайлан мэдээлэлтэй Хавсралт дахь үйл ажиллагааны тайлангаас танилцана уу.

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Б.Амарсайхан

Албан тушаал: "Говь" ХК-ийн Гүйцэтгэх захирал

Гарын үсэг:
(Тамга/тэмдэг)



Овог, нэр:


Албан тушаал: "..." Аудитын компанийн Гүйцэтгэх захирал

Гарын үсэг:
(Тамга/тэмдэг)

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: М.Сэлэнгэ

Албан тушаал: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Гарын үсэг: 

Огноо: 2025 оны 04-р сарын 18-ны өдөр